

БАТЛАВ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

А. Энхманлай

А.ЭНХМАНЛАЙ

2024 оны 02 дүгээр сарын 06-ны өдөр

Дугаар АЗ/2024-16

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х. Нямбаатар

Х.НЯМБААТАР

2024 оны 02 дүгээр сарын 09-ны өдөр

Дугаар

**БЭЛЧЭЭРИЙН ФОТО МОНИТОРИНГИЙН ЦЭГ ТӨЛӨӨЛӨХ
ТАЛБАЙГ НАРИЙВЧЛАН ЗУРАГЛАЖ, ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ЦАХИМ
СИСТЕМД ОРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Улаанбаатар хот

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3 дахь хэсэг; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Байгалийн ургамлын тухай хууль; - “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын хүрээнд 2021-2030 хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.6.10 дахь заалт, зорилт 8.3 дахь хэсэг; - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4.6 дахь заалт; - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.
2.	Ажлын зорилго	Нийслэлийн бэлчээрийн 210 га талбайн фото мониторингийн цэгийг төлөөлөх талбай (цаашид “төлөөлөх талбай” гэх)-г нарийвчлан зураглаж, Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загваруудтай холбож, Газрын мониторингийн цахим системд оруулах.
3.	Хамрах хүрээ	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн фото мониторингийн 5313 цэг бүхий Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн сан; - Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул, Багахангай, Багануур, Налайх дүүргийн фото мониторингийн 38 цэгийн 210 мянган га талбай; - Газрын мониторингийн цахим системийн “Бэлчээр” цэсэд хөгжүүлэлт хийгдэнэ.
4.	Ажлын иж бүрдэл	Газрын мониторингийн цахим мэдээллийн системийн “Бэлчээр” цэсэд нэмэлт зураглалын ажлыг гүйцэтгэж, шаардлагатай хөгжүүлэлт хийгдэнэ.

		<p>1. Бэлчээрийн газрын төлөөлөх талбайг зураглаж, Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвартай холбосон байна.</p> <p>2. Бэлчээрийн газрын төлөв байдлын дүн шинжилгээний статистик дашбоардыг хэрэглээнд оруулсан байна.</p>
5.	Гүйцэтгэх ажлын үе шат, хэмжээ	<p>Газрын мониторингийн цахим системийн “Бэлчээр” цэсэд дараах байдлаар хөгжүүлэлт хийгдсэн байна. Үүнд:</p> <p>1. Бэлчээрийн газрын фото мониторингийн цэг тус бүрийн төлөөлөх талбайг зураглаж оруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул, Багахангай, Багануур, Налайх дүүргийн 38 мониторингийн цэгийн төлөөлөх талбайг шинээр зураглах; - Бэлчээрийн фото мониторингийн цэг тус бүрийн талбайг газрын нэгдмэл сангийн зурагтай давхцуулан бэлчээрээс бусад ангиллын газраас салгаж зураглах; - Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцаж байгаа бэлчээрийн газрын хэмжээг гаргаж, зураглах; - Зурагласан нэг цэг төлөөлөх талбайн хил заагийг сансарын зураг, байрзүйн зурагтай давхцуулан шалгах, эцсийн байдлаар зураглах; - Фото мониторингийн нэг цэг төлөөлөх талбайг зураглаж, цэг тус бүрийг зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загваруудтай холбож, талбайг га-аар илэрхийлэх; - Бэлчээрийн мониторингийн нэг цэг төлөөлөх талбайг нийслэлийн хэмжээнд нэгтгэж, газрын мониторингийн цахим системийн улсын хэмжээний бэлчээрийн зураглалтай нэгтгэн холбох; - Бэлчээрийн сэргэх чадавхийн төлөв байдал нь доройтсон бэлчээрийн талбайг газрын мониторингийн цахим системийн нөхөн сэргээх, хамгаалах цэсрүү илгээх, оруулах байдлаар хөгжүүлэлт хийх. <p>2. Бэлчээрийн газрын төлөв байдлын дүн шинжилгээний статистик дүн шинжилгээний тайлан гаргах, өөрчлөлт хандлагыг харуулах дашбоардыг хэрэглээнд оруулах талаар дараах хөгжүүлэлтийг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн дүн шинжилгээ, өөрчлөлт хандлагын мэдээллийг харуулах статистик дашбоардыг улсын хэмжээгээр гардаг байдлаар системийг хөгжүүлэх; - Улсын хэмжээнд газрын мониторингийн цахим системд байгаа фото мониторингийн цэгийн нийт тоо, талбайтай нь улс, аймаг, сум, баг, бэлчээр ашиглагчийн хэсгийн түвшинд он тус бүрээр харуулдаг байхаар хөгжүүлэх; - Тухайн онд судалгаа хийгдээгүй мониторингийн цэгийн тоо, талбайтай нь улс, аймаг, сум, баг, бэлчээр ашиглагчийн хэсгийн түвшинд харуулдаг байхаар хөгжүүлэх; - Улсын хэмжээний мэдээнд үндэслэн улс, аймаг, сум, баг, бэлчээр ашиглагчийн хэсгийн түвшинд сэргэх чадавхийн ангиллыг, талбайгаар, цэгийн тоог он тус бүрээр харах байдлаар хөгжүүлэх;

		<ul style="list-style-type: none"> - Он тус бүрээр сэргэх чадавхийн 1-5 түвшний бэлчээр хамгаалах арга хэмжээг улс, аймаг, сум, баг, бэлчээр ашиглагчийн хэсгийн түвшинд талбайгаар ялган гаргах, мөн харах боломжтой байдлаар хөгжүүлэх; - Сэргэх чадавхийн ангиллыг улс, аймаг, сум, баг, бэлчээр ашиглагчийн хэсгийн түвшинд өмнөх онуудтай харьцуулан хувиар, мониторингийн цэгээр, талбайгаар харьцуулалт хийх байдлаар хөгжүүлэх; - Улс, аймаг, сум, баг, БАХ-ын түвшинд он тус бүрээр бэлчээрийн даацыг (даац-1, даац-1-100га, даац-2, даац-3, үнэлгээ) талбай, цэгийн тоо, биомасс, бодит ургацын хамт харуулдаг байдлаар хөгжүүлэх.
6.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газарт фотомониторинг хийх аргачилсан заавар”; - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/268 дугаар тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрыг экологийн чадавхаар зураглах заавар”; - Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай”; - Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд, 2018 он; - Газрын нэгдмэл сангийн бэлчээрийн талбайн тоон мэдээлэл, тайлан, 2022 он; - Газарзүйн мэдээлэл. Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт. MNS 6925-5 : 2021; - Газарзүйн мэдээлэл. Хөрсний орон зайн өгөгдлийн үзүүлэлт. MNS 6925-17 : 2021; - Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар”; - Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программ хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах; - Сүүлийн 6 сарын хугацаанд авсан 10 хүртэлх метрийн орон зайн шийдэлтэй сансрын зураг ашиглах.
7.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 4 сарны хугацаанд байна.
8.	Ажлын хяналт, шалгалт	<ul style="list-style-type: none"> - Захиалагчийн хяналтын зардлыг нийт үнийн дүнгийн 5 (таван) хувиар тооцно. - Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газрын мониторингийн хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны мониторингийн асуудал хариуцсан албан хаагчид хийнэ.
9.	Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> - Ажлын явцын үе шатны тайлан, цаас болон тоон хэлбэр /CD/-ээр – тус бүр 1 хувь; - Ажлын эцсийн үе шатны тайлан, цаас болон тоон хэлбэр /CD/-ээр – тус бүр 3 хувь; - Төлөөлөх талбайн нийслэлийн зураглалын тоон мэдээллийн сангийн эх код-3 хувь /CD/.

10.	Захиалагч байгууллага	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
11.	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Програм хангамж, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд.
12.	Санхүүжилт, эх үүсвэр	Урсгал зардал 45 000 000 төгрөг /Дөчин таван сая/
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг гэрээний нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА



А.АМАРСАЙХАН

ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ДӨЛ

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



Р.ОТГОНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХЦЭЦЭГ